



# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

20... оны 07 сарын 06-өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Хувьцаа хуваах, үнэт цаас  
шиинээр бүртгэх тухай

СЗХ-ны 2011 оны 05-р сарын 06-ны өдрийн 130 тоот тогтоол, “Силикат” ХК-ийн 2011 оны 05-р сарын 10-ны өдрийн 421/11 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, 2011 оны 7-р сарын 06-ны өдрийн Захирлын зөвлөлийн хурлын протоколыг үндэслэн **ТУШААХ НЬ**:

1. МХБ-д бүртгэлтэй “Силикат” ХК-ийн нэгж хувьцааг тус бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 177 ширхэг хувьцаанд хувааж, компанийн нийт гаргасан хувьцааны тоог 30,112,302 ширхэг болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. “Силикат” ХК-ийн олон нийтэд санал болгон нэмж гаргаж буй нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 16,222,300 ширхэг буюу 1.6 тэрбум төгрөгийн хувьцааг үнэт цаасны жагсаалтанд бүртгэсүгэй.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/, “Силикат” ХК /Ц.Содбилэг/-д үүрэг болгосугай.
4. “Силикат” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг холбогдох хууль, журам зааврын дагуу зохион байгуулахыг МТА /Б.Чингүнжав/, АСА /Г.Саруул/-д, зохих мэдээллийг олон нийтэд түгээн ажиллахыг МОНХА /Т.Хулан/-д даалгасугай.
5. “Силикат” ХК-ийн журам болон “Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ”-гээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг БА /М.Энхтуяа/, ХА /Т.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.



Х.АЛТАЙ